

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Мөрөн

Шийд- вэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгуулла- гын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1. Монгол Улсын хууль							
1	1	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын даргын баталсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн 2023 оны байдлаар дараах арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд: • Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу нийт албан хаагчдын цалинг Хэлтсийн даргын 2023 оны А/08 тушаалаар шинэчлэн баталсан. • Төрийн үйлчилгээний 3 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг нэмж олгосон. • Шадар сайдын 2023 оны 19 дүгээр тушаалаар 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан.	100		
2	2	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ	10.2.2.сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу	Тус хэлтсээс Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг 7 Ерөнхий боловсролын сургуулиудад хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд мөрдөх MNS 4946:2019 стандартыг хүргүүлж ажилласан. Байгууллагын харьяа Сорилтын итгэмжлэгдсэн лабораториор	70		

		2019-05-30 Дугаар 2019.05.30	боловсруулж, батлуулах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	дамжуулан аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн хоолонд тухайн байгууллагын хүсэлтийн дагуу шинжилгээ хийн ажиллаж байна.			
3	3	НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Цахим хуудсанд 178 мэдээ байршуулсанаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 64 мэдээ, иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл түгээх зорилгоор шторк, контент, нийт 114 мэдээг тус тус байршуулсан бөгөөд нийт 2500 хүн хандалт хийсэн байна. Байгууллагын мэдээллийн самбарыг шинэчлэн байршууллаа. Үндсэн чиглэлээр мэдээллүүдийг холбогдох албан хаагчид тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100		
	4		8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Тус хэлтэс нь Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан бүтэц орон тооны хүрээнд ажлын чиг үүргээ хэрэгжүүлж байна. Байгууллагын <a href="https://masm.gov.mn/hvl/">https://masm.gov.mn/hvl/</a> вэб сайт, Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс фэйсбүүк цахим хуудас, мэдээллийн самбарт олон нийтэд мэдээллийг хүргэн ажиллаж байна.	100		
	5		8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан,	Засгийн газрын хуралдааны үүрэг даалгаврын биелэлт, Стандарт хэмжил зүйн газрын даргын тэмдэглэлээр өгөгдсөн	100		

		мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	үүрэг даалгавруудыг хяналтад авч төлөвлөгөө гарган ажиллаж байна. Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн зөвлөмжийг хагас жилийн тайланд тусган хэрэгжүүлж ажиллалаа.			
	6	8.2.4.хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Тус хэлтэс үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжуудыг хяналтад аван ажиллаж байна. 5 хуулийн 47 заалт, Ерөнхийлөгчийн 2 зарлиг, Засгийн газрын 14 тогтоол, Засгийн газрын 8 хуралдааны тэмдэглэлийн 13 заалтыг хяналтад аван цаг тухай бүр тайлагнан ажиллаж байна. Хагас жилийн тайланд хийсэн хяналт, шинжилгээний мөрөөр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүрт хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлж ажилласан.	100		
	7	8.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу Засгийн газраас баталсан Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон нутгийн захиргааны байгууллагаас баталсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг холбогдох журмын дагуу тайлагнаж ажиллаж байна.	100		
	8	8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай, Хэрэглэгчийн тухай, Эрчим хүчний тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Иргэдээс	100		

				төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.			
	9		8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Стандарт хэмжил зүйн даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/86 тоот тушаалаар төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт батлагдсан. Албан хаагчдын өрөөний хаягт утасны дугаар, албан тушаалыг бичиж байршуулсан.	100		
	10		8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Энэ онд 270 иргэн, аж ахуйн нэгжээс тохирлын гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн бөгөөд Баталгаажуулалтын хурлаар ирсэн хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлын мэдээг улирал бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.	100		
	11		8.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Тохирлын гэрчилгээ олгосон аж ахуйн нэгж, иргэнийг <a href="https://masm.gov.mn/hvl/apanel/login">https://masm.gov.mn/hvl/apanel/login</a> цахим мэдээллийн санд шивж байна. Мөн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг <a href="https://masm.gov.mn/hvl">https://masm.gov.mn/hvl</a> вэб хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэж ажиллаж байна.	100		
	12		8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Байгууллагын мэдээлэл Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс цахим хуудас, <a href="https://masm.gov.mn/hvl">https://masm.gov.mn/hvl</a> вэб сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргүүлэн ажилласан байна. Байгууллагын ажлын чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах зорилгоор “Бидний үйл ажиллагаа–Таны нүдээр” уриатай Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт бүх төрлийн хэмжих	100		

			<p>хэрэгслийн баталгаажуулалт, явуулын лабораторийн үйлчилгээг үзүүлж байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, таниулах, иргэдээс гарсан санал гомдлыг газар дээр нь шийдэх боломжтой асуудлыг нь шийдэж ажилласан. Мөн Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр баярын талбайд явуулын лабораторийн үйл ажиллагааг танилцуулж туршилт хийж ажилласан. Стандарт ба хөгжил үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 02 дугаар сарын 27-ны өдөр Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хурлын танхимд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагын 50 гаруй төлөөлөл оролцож үндэсний хөтөлбөрийн төсөлд саналаа өгсөн бөгөөд саналыг нэгтгэн Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газартай хамтран 11 дүгээр сарын 20-ны өдөр “Эрсдэл ба стандарт” үндэсний форумыг “Соёмбо” танхимд зохион байгууллаа. Тус форумд холбогдох төрийн байгууллагууд илтгэл мэдээлэл хийж, төрийн болон төрийн бус байгууллагын 160 гаруй төлөөлөл оролцож санал солилцлоо. Форумд гарсан санал, тайланг Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.</p>				
	13		<p>8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;</p>	<p>Төрийн захиргааны 1 албан тушаалын сонгон шалгаруулалтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд захиалгыг хүргүүлсэн. Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс фэйсбүүк хуудсаар</p>	100		

				болон Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан ёсны цахим хуудас, вэб хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл хүргүүлсэн.			
	14		8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Төрийн захиргааны албан хаагчийг сонгон шалгаруулахдаа Төрийн албаны тухай хуулийн дагуу Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд 1 ажлын байрны захиалгыг хүргүүлж журмын дагуу шалгалтаа өгч тэнцсэн иргэнийг томилон ажилласан.	100		
	15		8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн баримтлан ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, албан хаагчдад сургалт мэдээлэл хийж ажиллаж байна.	100		
	16		8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах тухай Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70		
	17		8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөн ажиллаж байна.	100		
	18		8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын	100		

				<p>дагуу Хэлтсийн даргын 2023 оны А/06 тоот тушаалаар Үнэлгээний баг байгуулагдаж албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэж байна.</p> <p>Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг жилийн эцсээр Үнэлгээний баг үнэлж дүгнэсэн.</p>			
	19		8.4.1.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	<p>2022 оны төсөв 173,3 сая төгрөг үүнээс өөрийн орлого 40,0 сая төгрөг.</p> <p>2022.12.31 өдрийн байдлаар нийт орлого 51,566,270 орсон бөгөөд 11,566,270 төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан.</p> <p>2023 оны төсөв 359,989,9 сая төгрөг үүнээс өөрийн орлого 83,0 сая төгрөг. Тус хэлтсийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 83,450,000 орсон орлого 106,715,870 орсон байна.</p> <p>2024 оны төсвийн төсөл 410,959 сая төгрөг хэлтсийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 60,000,000 байхаар төлөвлөж Стандарт, хэмжил зүйн газрын Санхүүгийн албанд хүргүүлсэн.</p>	100		
	20		8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	<p>Тус хэлтсийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө хагас жилээр 32,250,000 төгрөг гүйцэтгэл 49,472,400 төгрөг, бүтэн жилээр төлөвлөгөө 83,000,000 төгрөг гүйцэтгэл 106,715,870 төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.</p>	100		

				Тайлант онд санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн үндсэн зарчмуудтай нийцүүлэн зохистой удирдан ажиллаж байна.			
	21		8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн албан бичгээр баталгаажиж “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт авсан.	100		
	22		8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	2023 оны байгууллагын 100170009001 тоот дансанд нийт 106,715,870 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан. Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлийг задлан харуулбал: Цахилгаан хэмжих хэрэгслийн баталгаажуулалт – 11,349,200 төгрөг, Механик хэмжих хэрэгслийн баталгаажуулалт –11,391,000 төгрөг, Эзлэхүүний хэмжих хэрэгслийн баталгаажуулалт – 7,650,000 төгрөг, Дулаан даралтын хэмжих хэрэгслийн баталгаажуулалт– 4,509,600 төгрөг, Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт–35,886,000 төгрөг, Стандартын салбар сан – 2,868,470 төгрөг Лабораторийн шинжилгээ- 33,061,600 төгрөг	100		



	23		8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Байгууллагын 2023 оны батлагдсан төсөв 359,989.9 сая төгрөг. Хэмнэлт: Цалингийн зардлаас хэмнэлт хийсэн үүний шалтгаан нь байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөхдөө төрийн жинхэнэ албан хаагчаар түр орлон гүйцэтгэсэн. Хэтрэлт: Байр ашиглалттай холбоотой халаалтын зардал их гарч байна.	100		
	24		8.4.6.Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Тус хэлтэс маань худалдан авалтын зардал бага тул таван сая, төгрөгнөөс дээш худалдан авалт энэ онд хийгдээгүй. Бараа материал худалдан авах тохиолдолд гэрээт байгууллагуудаас худалдан авалт хийдэг.	ҮБ		
	25		8.4.7.Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Тус хэлтсийн үйл ажилгаанд 5 сая төгрөгөөс дээш 2 удаа орлогын гүйлгээ бүртгэгдсэн энэ нь борлуулалтын орлого болон Механик хэмжих хэрэгслийн үйл ажиллагааны орлого болно. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдээгүй.	100		
	26		8.4.8.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Төрийн болон, орон нутаг бусад эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажил тайлант хугацаанд хийгдээгүй.	ҮБ		

	27		8.4.9.Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	2023 оны байдлаар <a href="https://shilendans.gov.mn/">https://shilendans.gov.mn/</a> цахимд 163 мэдээлэл оруулахаас 151 мэдээлэл оруулсан, 12 мэдээлэл хугацаа болоогүй байна. Байгууллагын санхүү төсвийн ил тод байдлын мэдээллийн самбарт 2023 оны Бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, 2023 оны батлагдсан төсвийн хуваарь, 2022 оны санхүүгийн жилийн эцсийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулж албан хаагчид, иргэд олон нийтэд мэдээлэн ажиллалаа.	100		
	28		8.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	Төрийн болон, орон нутаг бусад эх үүсвэрээр хэрэгжсэн худалдан авах ажиллагаа тайлант хугацаанд хийгдээгүй болно.	ҮБ		
	29		8.4.11.Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж аудитаар баталгаажуулж, Сангийн яамны е-тайлан цахим мэдээллийн санд бүрэн эхээр шивж оруулсан. Мөн 2023 оны хагас жилд аудитын өгсөн зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллаж байна.	100		

	30		8.4.12.Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Төрийн болон, орон нутаг бусад эх үүсвэрээр хэрэгжсэн худалдан авах ажиллагаа тайлант хугацаанд хийгдээгүй болно.	ҮБ		
	31		8.4.26.Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Тус хэлтсийн хувьд 2023 онд төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй.	ҮБ		
	32		8.4.27.Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Захиалгаар хийгдсэн ажил байхгүй болно.	ҮБ		
	33		8.4.28.Хууль тогтоомжид заасан бусад.(8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Хууль тогтоомжид заагдсан мэдээллүүдийг олон нийтэд хүргэхийн зэрэгцээ байгууллагын албан хаагчдад санхүүгийн тайлан мэдээг ил тод мэдээллэх ажлын хүрээнд байгууллагын санхүүгийн ил тод байдлыг самбарыг бий болгон сар бүрийн тайлан мэдээг байршуулж шаардлага гарсан тохиолдолд албан хаагчдыг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Нийгмийн даатгал, татварын тооцоог сар бүр тулган баталгаажуулж байна.	100		
	34		8.5.1.Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын	Тохирлын гэрчилгээ авахад бүрдүүлэх материалын жагсаалт, төлбөр төлөх дансны дугаар, үйлчилгээний хөлсний хэмжээ, бусад холбогдох мэдээг <a href="https://masm.gov.mn/hvl/">https://masm.gov.mn/hvl/</a> , Хөвсгөл аймгийн	100		

		үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Стандарт, хэмжил зүйн хэлтэс цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.			
35		8.5.2.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тус хэлтсийн үйл ажиллагааны хамрах хүрээнд тусгай зөвшөөрөл олгох үүрэг хүлээгээгүй болно.	ҮБ		
36		8.6.1.Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Стандарт ба хөгжил үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагын 50 гаруй төлөөлөл оролцож үндэсний хөтөлбөрийн төсөлд саналаа өгсөн бөгөөд саналыг нэгтгэн Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлыг газартай хамтран 11 дүгээр сарын 20-ны өдөр “Эрсдэл ба стандарт” үндэсний форумыг “Соёмбо” танхимд зохион байгууллаа. Тус форумд холбогдох төрийн байгууллагууд илтгэл мэдээлэл хийж, төрийн болон төрийн бус байгууллагын 160 гаруй төлөөлөл оролцож санал солилцлоо. Форумгаас гарсан тайланг Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт-	100		

			шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.			
37		8.6.2.эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Тус байгууллагын хувьд эзэмшиж байгаа оюуны өмчийн эрх байхгүй болно.	ҮБ		
38		8.6.3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэр 2023 онд гараагүй болно.	ҮБ		
39		8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багт тус хэлтсийн албаны байр байрлах бөгөөд Шүүх шинжилгээний хэлтсийн байрны 3, 4 дүгээр давхарт байрлан үйл ажиллагаа явуулж байна.	100		
40		8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд байхгүй болно.	ҮБ		
41		8.6.6.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон	Хамааралгүй заалт.	ҮБ		

		гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;				
	42	8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Байгууллагын өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулаагүй болно.	ҮБ		
	43	8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Хамааралгүй заалт.	ҮБ		
	44	8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад	Хамааралгүй заалт	ҮБ		

			оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;				
	45		8.6.20.нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	<a href="https://estandard.gov.mn/">https://estandard.gov.mn/</a> цахим хуудаст нээлттэй байршуулсан мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж хүлээн авч байна.	100		
	46		8.6.21.мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Стандарт, хэмжил зүйн газрын төлөвлөгөөт сургалт, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулж байгаа сургалтуудад байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан. Албан байгууллагын зардлаар мэргэжил дээшлүүлэх болоод мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй болно.	ҮБ		
	47		8.6.22.хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Байгууллагын <a href="https://masm.gov.mn/hvl/">https://masm.gov.mn/hvl/</a> цахим хуудаст нээлттэй байршуулсан.	100		
Ерөнхийлөгчийн зарлиг							
4	48	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-03 Дугаар 2018_46	3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх	Албан хаагчдын өрөөний дугаар, албан тушаалын нэр, өөрийн нэр, утасны дугаарыг кирилл болон монгол бичгээр хослуулан бичиж байршуулсан. Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдад “Хүмүүн бичиг” сонинг захиалсан.	100		

			санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.			
5	49	Засгийн газарт чиглэл тухай 2022-04-05 Дугаар_43	1.4.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Салбарын Хөдөлмөрийн дотоод журамд энэхүү заалтыг тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100	
	50		2.Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Архи согтууруулах ундааны хэрэглээгээ багасгаж эрүүл амьдрах, иргэдийг зөв дадалд уриалах нөлөөллийн ажлыг байгууллагын хэмжээнд хийж байна. Тухайлбал албан хаагчид “Амьдрах орчноо архи, согтууруулах ундаагүй инээмсэглэл, хайр дүүрэн байлгая” гэсэн уриалгыг хүргэж байна. Мөн архи согтууруулах ундааны хор хөнөөл, түүнээс хэрхэн салах тухай зөвлөмж, архи согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглэлт ямар хор уршгийг дагуулж байна гэхчлэн нөлөөллийн постеруудыг байгууллагын цахим хуудсанд байршуулж байна. Статистик тоо баримт бүхий нөлөөллийн постерууд, видео бичлэгүүдийг олон нийтийн сүлжээнд байршуулж иргэдэд уриалгыг хүргэх нөлөөллийн ажлуудыг хийж байна.	100	



Засгийн газрын тогтоол						
6	51	ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ 2018-08-22 Дугаар 2018_258	1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;	Иргэд, аж ахуйн нэгжээс ирсэн 270 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн холбогдох хариуг өгч ажилласан. Өргөдөл гомдлын улирал бүрийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.	100	
	52		1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Төрийн захиргааны албан хаагчийг сонгон шалгаруулахдаа Төрийн албаны тухай хуулийн дагуу Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд 1 ажлын байрны захиалгыг хүргүүлж журмын дагуу шалгалтаа өгч тэнцсэн иргэнийг томилон ажиллаж байна.	100	
	53		1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах	Тус хэлтсийн даргын сонгон шалгаруулах тусгай шалгалт 2022 оны 04 сард зохион байгуулагдаж шаардлага хангасан 3 иргэн өрсөлдөж хамгийн өндөр оноо авсан Д.Батцоож Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 05 дугаар сарын 18-ний өдрийн	100	

		албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох;	363 дугаар тогтоолоор нэр дэвшиж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны Б/106 дугаар тушаалаар томилогдон ажиллаж байна.			
54		1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа албан хаагчийн сул орон тоонд төрийн албаны нөөцөд байгаа иргэнийг томилон ажиллуулж байна.	100		
55		1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг,	Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар батлагдсан салбарын хөдөлмөрийн дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсэгт захиргаа, төрийн албан хаагчийн эрх үүрэг, хориглох заалт хэсэгт албан томилолт, ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхийг	100		

		тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	хориглосон заалтыг оруулан мөрдлөг болгон ажиллаж байна.			
56		1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Тус хэлтсийн албан хаагчид 2023 онд ямар нэгэн гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч байхгүй болно.	100		
57		1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем "ERP" системээр хяналт тавьж ажиллаж байна.	100		
58		1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах	Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар батлагдсан “Стандарт, хэмжил зүйн салбарын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар хэсэгт заасан Захиргаа, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, хориглох зүйлд заасан заалтыг мөрдөн ажиллаж байна.	100		

			орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;				
	59		3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд 7 хоног бүрийн Даваа гараг бүр өмнөх 7 хоногийн хийсэн ажлын мэдээлэл сонсох, ирэх 7 хоногийн хийгдэх ажлуудын төлөвлөгөөний талаар санал солилцох дотоод уулзалтыг хийж хэвшсэн.	100		
7	60	Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019-03-21 Дугаар 2019_111	2.Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр	Хамааралгүй заалт.	ҮБ		

			эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.				
8	61	ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2019-04-17 Дугаар 2019_149	3.Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд хандан авах замаар шийдвэрлэх, "Үйлчилгээний нэгдсэн төв"-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй.	Хамааралгүй заалт.	ҮБ		
9	62	Жагсаалт батлах тухай 2020-01-22 Дугаар 2020_21	3.Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн гэрээг тухай	Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.	ҮБ		

			бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай.				
10	63	ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ 2020-03-18 Дугаар 2020_95	3. Тэргүүлэх чиглэлд тусгагдсан инновацийн үйл ажиллагааны арга хэмжээг өөрсдийн үйл ажиллагааны жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, тухайн арга хэмжээнд батлагдсан төсөвт эх үүсвэрийн дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хамааралгүй заалт.	ҮБ		
11	64	БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ СУНГАХ ТУХАЙ 2020-03-25 Дугаар 2020_106	4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай.	Хэрэгжилтийг тооцох хугацаа дууссан.	ҮБ		
12	65	УЛСЫН ҮЗЛЭГИЙН МӨРӨӨР АВАХ ЗАРИМ АРГА	1."Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр	Энэ онд архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг болоогүй.	ҮБ		

		ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-03-22 Дугаар 2020_102	дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.				
	66		2.Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч үүрэг болгосугай.	Байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах зардлыг бичиг хэргийн зардалд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	100		
13	67	МАЛ АЖ АХУЙН ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ АШИГЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-05-13	2."Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах арга хэмжээ авах, паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эрчимжүүлэхийг нийслэлийн Засаг дарга С.Амарсайханд, малын гаралтай түүхий эд	Хамааралгүй заалт.	ҮБ		

		Дугаар 2020_178	боловсруулах үйлдвэрийн цэвэршүүлсэн технологийн бохир усыг үйлдвэрт дахин ашиглах стандарт боловсруулж, батлуулахыг Стандарт, хэмжил зүйн газар (Б.Билгүүн)-т тус тус даалгасугай.				
14	68	БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭНТЭ Й ХОЛБОГДУУЛАН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-11-18 Дугаар 2020_183	19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.	ҮБ		
15	69	Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар 2021_359	4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулан ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах	Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.	ҮБ		



			ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай.				
16	70	ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-05-25 Дугаар 2022_203	1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2.жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг	1.1 Тус хэлтэст хориглохоор заагдсан албан тушаалын орон тоо байхгүй болно. 1.2 2023-2025 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг 2022.04.15-ны өдөр Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын 21 дугаартай албан тоотын хамт цахимаар болон Стандарт, хэмжил зүйн газарт шуудангаар цаг хугацаандаа хүргүүлж ажиллалаа. 1.3 Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэмжих хэрэгсэл баталгаажуулах ажлууд нь цахимаар зохион байгуулах боломжгүй ажил бөгөөд 2023 онд 23 сум, 1 тосгоны аж ахуйн нэгж, иргэний хэмжих хэрэгсэл болоод бүтээгдэхүүн, үйлчилгээнд хүрч үйлчлэн баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. 1.4 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 2023 онд тус хэлтэст төлөвлөгдөөгүй болно.			100

			<p>төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;</p> <p>1.3.байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;</p> <p>1.4.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.</p>			
71	ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ	<p>1.Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон</p>	<p>Стандарт, хэмжил зүйн салбарын онцлогоос шалтгаалан баталгаажуулалтын ажлыг хийхэд зайлшгүй авто машин ашиглахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсдэг. Тус хэлтэс нь Land cruiser 100, Фургон авто машинуудтай бөгөөд ашиглалтын хугацаа дууссан. Актлах тухай саналаа Стандарт, хэмжил зүйн газарт хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлэн ажилласан.</p>	100		

17		<p>ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-05-25 Дугаар 2022_204</p>	<p>нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>				
	72		<p>9.Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой</p>	Хамааралгүй заалт.	ҮБ		

			хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.			
18	73	МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-05 Дугаар 2022_7	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:</p> <p>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;</p> <p>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;</p> <p>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний</p>	<p>5.1 Хамааралгүй заалт.</p> <p>5.2 Үндсэн үйл ажиллагааны талаар мэдээллийг Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс <a href="https://masm.gov.mn/hvl/">https://masm.gov.mn/hvl/</a> болон фэйсбүүк хуудаст монгол бичгээр бичиж иргэд олон нийтэд түгээж ажиллаж байна.</p> <p>5.3 Албан хэрэг хөтлөлтийн ажилтанг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас зохион байгуулсан монгол бичгээр бичих арга зүйд суралцах сургалтад хамрагдлаа.</p> <p>Албан бичиг, шийдвэрийг монгол бичгээр бичих албан бланкын захиалгыг Хонгор хэвлэлийн ХК -д хүргүүлсэн.</p> <p>5.4 Стандарт, хэмжил зүйн газраас зохион байгуулж байгаа монгол бичгийн танхимын сургалтад албан хаагчид хамрагдаж байна.</p> <p>5.5 Албан хаагчдын өрөөний дугаарыг кирилл болон монгол бичгээр хослуулан бичиж байршуулсан.</p>	100	

			бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
19	74	2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19	II.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удаарширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Хамааралгүй заалт.		ҮБ	
20	75	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрө 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55	XV.9.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл,, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Хамааралгүй заалт.		ҮБ	

			боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав.				
21	76	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	ХҮИИ.17.2 Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав.	Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.	ҮБ		
	77		ХҮИИ.17.3 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Хамааралгүй заалт.	ҮБ		

22	78	2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2022-04-13 Дугаар 2022_22	XI.2. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, спортын холбоодын тэргүүн, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, төрийн өмчит компани болон үйлдвэрийн газрын удирдлага, захирлуудад даалгав.	Хамааралгүй заалт.	ҮБ		
23	79	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7 Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж	Байгууллагын албан хаагчид аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс тоон гарын үсэг авсан. Хэлтсийн дарга тоон гарын үсэг ашиглан бусад байгууллага хооронд албан бичиг явуулж байна.	100		

			ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.				
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
24	80	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг, нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Байгууллагын албан хаагчид аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс тоон гарын үсэг авсан. Төрийн үйлчилгээ авахад ашиглаж байна.	70		
	81		1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж нийтэд сурталчлах;	Цахим хуудсанд 178 мэдээ байршуулснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 64 мэдээ, иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл түгээх зорилгоор шторк, контент, нийт 114 мэдээг тус тус байршуулсан бөгөөд нийт 2500 хүн хандалт хийсэн байна. Байгууллагын мэдээллийн самбарыг шинэчлэн байршууллаа. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой чиглэлээр мэдээллүүдийг холбогдох албан хаагчид тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100		
	82		1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн системд”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем “ERP”-ийг 2021 оноос хойш нэвтрүүлсэн. Тус ERP-системээр дамжуулан албан бичгээ байгууллага хооронд цахим хэлбэрээр солилцож байна.	100		
Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж							



25	83	Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж 2022-12-09 Дугаар 2022_214	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	Хэрэгжилтийг тооцох хугацаа дууссан.	ҮБ		
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ:							98,3

ХЯНАСАН:  
 СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
 ДАРГА Д.БАТЦООЖ

НЭГТГЭСЭН:  
 СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МАНДАХБАЯР